

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ” НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.” заасныг үндэслэн Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг тайланг хяналаа.

1. Аудитын зорилго

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн төвлөрүүлсэн орлого, иргэн, хуулийн этгээдийн өгсөн хандив болон сонгуулийн зардлыг хянаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, нийтэд мэдээлнэ.

2. Үндсэн мэдээлэл

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд 37-н тойрогт 3 намын 90 нэр дэвшигч, 5 бие даагч нийт 95 нэр дэвшигч, 23 сумын ИТХ-ын сонгуулийн 128 тойрогт 3 намын 1062 нэр дэвшигч, 1 бие даан нэр дэвшигч нийт 1063 нэр дэвшигч аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 1158 нэр дэвшигч сонгуульд өрсөлдсөн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

№	Нам, бие даан нэр	Нэр дэвшигч	Бие даагч
1	Монгол Ардын нам /МАН/	558	
2	Ардчилсан нам /АН/	555	
3	Монгол Ардын Хувьсгалт нам /МАХН/	39	
4	Бие даагч		6
Нийт		1158	

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд нэр дэвшсэн 1158-н нэр дэвшигчээс Бүрэнтогтох сумын ИТХ-ын сонгуульд тус сумын 3-р тойрогт Монгол Ардын намаас нэр дэвшсэн Батбаярын Гэрэлцогт сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан ирүүлээгүй байна.

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/16, А/17 дугаар тушаалаар аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, нэр дэвшигч, бие даагчаас зарцуулах зардлын дээд хэмжээг багт 8.5-38.6 сая төгрөг, суманд 16.3-27.6 сая төгрөг, аймагт 19.8-74.6 сая төгрөгөөр баталсан. Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын хэмжээг хэтрүүлээгүй байна.

3. Хуулийн дагуу мэдээлэх хандив.

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1¹-д заасны дагуу нам, эвсэл, нэр дэвшигчид нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Орон нутгийн сонгуульд оролцсон намын тухайд: Монгол Ардын намын хороонд 15-н иргэнээс 27.6 сая төгрөг, Эрдэнэбулган сумын Ардчилсан намын хороонд 2 иргэнээс 3.5 сая төгрөг нийт 17 иргэнээс 31.1 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Хүснэгт №2

Иргэнээс өгсөн мөнгөн хандив				
№	Аймаг, сумын нэр	Намын нэр	Иргэний овог, нэр	
			Дүн /сая төгрөг/	
1	Хөвсгөл аймаг	МАН	Ч.Оюунчимэг	2.0
			Б.Мөнхсайхан	2.0
			Ж.Түмэн-Очир	1.6
			П.Алтансолонго	2.0
			П.Уянга	2.0
			Б.Нарантуяа	2.0
			Б.Долзодмаа	1.6
			Н.Өлзийбат	2.0
			Х.Жаргалмаа	2.0
			Л.Эрдэнэ-Уул	2.0
			Г.Лхагвасүрэн	2.0
			Б.Батбаяр	2.0
			Д.Цогтоо	2.0
			Ж.Ганболд	2.0
			Д.Даваадорж	1.0
2	Эрдэнэбулган сум	АН	Б.Эрдэнэнаран	2.0
			П.Ариунбат	1.5
Дүн				31.1

Хуулийн этгээдээс нам, нэр дэвшигчид өгсөн хандивын тухайд: Орон нутгийн сонгуульд оролцсон нам, эвсэлд хуулийн этгээдээс хандив өгөөгүй байна. Харин МАН-ын нэр дэвшигчид 1, бие даан нэр дэвшигчид 1 нийт 2 нэр дэвшигчид хуулийн этгээдээс нийт 6.5 сая төгрөгийн хандив өгсөн байна.

Хүснэгт №3

№	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандив	
			Хуулийн этгээдийн нэр	Дүн /сая төгрөг/
1	МАН	Б.Нямдаваа	“Хүслэнт бүтээмж”ХХК	3.0
2	Бие даагч	Д.Лхагвасүрэн	“Хөвсгөл зам” ХХК	3.5
Дүн				6.5

¹ ... нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ.

Иргэнээс нэр дэвшигчд өгсөн хандивын тухайд: Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон 41 нэр дэвшигчид 57 иргэнээс нийт 77.7 сая төгрөгийн хандив өгсөн байна. **Хүснэгт №4**

№	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Иргэнээс өгсөн мөнгөн хандив	
				Иргэний нэр	Дүн /сая төгрөг/
1	Аймаг 28-р тойрог	МАН	П.Ганзориг	Б.Энхбилэг	1.8
2	Аймаг 11-р тойрог	МАН	Ж.Ариунаа	Б.Мөнхбат	1.8
3	Аймаг 35-р тойрог	МАН	Ц.Гансүх	Б.Ганнасан	1.0
4	Аймаг 12-р тойрог	МАН	А.Мөнх-Эрдэнэ	Д.Батбаяр	1.5
5	Аймаг 15-р тойрог	АН	Л.Даваабаяр	Л.Төмөрбаатар	1.0
6	Аймаг 26-р тойрог	АН	Г.Сүхбаатар	Г.Отгонцэцэг	1.0
				Г.Сүхбат	2.0
				А.Цэцэгмаа	2.0
				Б.Бат-Эрдэнэ	2.0
7	Аймаг 30-р тойрог	Бие даан нэр дэвшигч	Д.Лхагвасүрэн	Б.Одончимэг	1.0
				М.Наранцэцэг	1.2
				Л.Батсүрэн	1.2
8	Мөрөн сум 9-р тойрог	МАН	Б.Буян-Өлзий	Н.Оюунцэрэн	1.0
9	Мөрөн сум 11-р тойрог	МАН	Б.Батпүрэв	Ч.Батнасан	1.0
10	Мөрөн сум 3-р тойрог	МАН	Ч.Батсүх	Ч.Баттулга	1.0
11	Мөрөн сум 7-р тойрог	МАН	Б.Лхагвадорж	Х.Энх-Амар	2.0
12	Мөрөн сум 9-р тойрог	МАН	Б.Нямдаваа	Д.Алтантуяа	2.0
13	Мөрөн сум 11-р тойрог	МАН	Ч.Лонжид	Н.Батсайхан	1.1
14	Мөрөн сум 14-р тойрог	МАН	Д.Идэрмөнх	П.Даваахүү	1.0
15	Аймаг 31-р тойрог	АН	Ш.Идэрбаясгалан	Ш.Идэрцогт	2.0
				Ш.Азжаргал	1.0
				Д.Шаравдорж	2.0
16	Аймаг 31-р тойрог	АН	Б.Батжаргал	О.Баатар	1.0
17	Аймаг 27-р тойрог	АН	Б.Мөнгөн-Эрдэнэ	Н.Оюундэлгэр	1.0
18	Аймаг 21-р тойрог	Бие даан нэр дэвшигч	Д.Ган-Эрдэнэ	Д.Баясгалан	1.0
				А.Ариунгэрэл	1.0
				Д.Мөнх-Эрдэнэ	1.0
19	Мөрөн сум 4-р тойрог	МАН	Г.Уранбилэг	М.Энхмандах	1.0

20	Мөрөн сум 5-р тойрог	МАН	С.Энхбат	С.Наранцэцэг	1.8
21	Бүрэнтогтох сум 3-р тойрог	АН	М.Эсмэдэх	М.Пүрвээ	1.0
22	Тариалан сум 6-р тойрог	МАН	Д.Батжаргал	Н.Нармандах	1.7
23	Аймаг 10-р тойрог	МАН	А.Тунгалаг	Ц.Төрмөнх	1.0
24	Мөрөн сум 9-р тойрог	МАН	Ц.Зоригт	Ц.Очирбат	1.0
25	Мөрөн сум 2-р тойрог	МАН	Э.Нямцэрэн	Б.Бадмаа	1.4
26	Мөрөн сум 2-р тойрог	МАН	М.Лянхуа	Б.Түмэн-Өлзий	1.5
27	Мөрөн сум 5-р тойрог	МАН	Г.Долгорсүрэн	П.Аюушжав Г.Жүгдэр	1.0 1.0
28	Мөрөн сум 8-р тойрог	МАН	А.Дэлгэрсүрэн	Д.Оюун	1.0
29	Мөрөн сум 8-р тойрог	МАН	Э.Инжир	С.Цогтоо Б.Батмаа	1.1 1.0
30	Мөрөн сум 12-р тойрог	МАН	Р.Элбэг-Очир	Н.Нансалмаа	2.0
31	Аймаг 25-р тойрог	МАН	Б.Батбаяр	В.Жавзансүрэн Х.Жаргалмаа	1.0 1.3
32	Аймаг 26-р тойрог	МАН	Г.Энхбаяр	Х.Баярсайхан	1.0
33	Аймаг 23-р тойрог	МАН	Г.Баттулга	Б.Жавхлантуяа	1.9
34	Аймаг 10-р тойрог	МАН	Ц.Хөвсгөлдалай	Х.Отгонцэцэг Х.Гантуул Г.Сүхээ	1.0 2.0 1.0
35	Аймаг 33-р тойрог	МАН	Х.Тайванбаяр	Э.Очбаяр	2.0
36	Аймаг 29-р тойрог	МАН	Л.Ганболд	Д.Саранцэцэг Ш.Даш-Очир	2.0 2.0
37	Аймаг 31-р тойрог	МАН	Л.Амарболд	Ч.Отгонбаяр	1.8
38	Аймаг 24-р тойрог	МАН	Б.Түвшинжаргал	Б.Өнөболд	1.0
39	Мөрөн сум 4-р тойрог	МАН	Ч.Алтангэрэл	Р.Нарантуяа Ц.Дарьсүрэн	1.0 1.5
40	Мөрөн сум 9-р тойрог	МАН	Ө.Нямсүрэн	Н.Нямсүрэн	1.1
41	Аймаг 25-р тойрог	МАН	С.Сарангэрэл	Т.Нямгэрэл	2.0
Дүн					77.7

4. Сонгуулийн зардлын тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Хувийн аудитын компаниудаас Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.5²-т заасны дагуу буцах хаяг тодорхойгүй дараах гүйлгээнүүдийг тухайн сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна:

- Мөрөн сумын ерөнхий орлогын дансанд 30,200 төгрөгийн дүнтэй 1 гүйлгээ.
- Түнэл сумын ерөнхий орлогын дансанд 20,000, 230,000, 70,000 төгрөг нийт 320,000 төгрөгийн 3 гүйлгээ.

5. Аудитын дүгнэлт


Хөвсгөл аймгийн аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцсон 3 нам, Ардчилсан намын сумдын 23 хороо, 1157 нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг аудитын хуулийн этгээдүүд үнэн зөв, иж бүрэн илэрхийлэгдсэн гэж дүгнэлт гаргасан байна.

БОЛОВСРУУЛСАН АУДИТОР

Н.ГҮРБАЗАР

ХЯНАСАН: ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

О.ГАНБОЛД



² Буцах хаяг нь тодорхойгүй хандивыг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын орлогод буюу төрийн санд шилжүүлнэ.